

2014 ОНЫ 7 ДУГААР САРЫН ДААТГАЛЫН МЭДЭЭ

2014 оны 08 дугаар сарын 20

1. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ:

2014 оны 7 дугаар сарын байдлаар даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн бүртгэлд дараах өөрчлөлт орсон байна.

/тоогоор/

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчид	2014.07.01	Нэмэгдсэн	Хасагдсан	2014.07.30
1	Даатгалын компани	17			17
2	Даатгалын компанийн салбар	254			254
3	Даатгалын төлөөлөгч	3399	37 ¹	61 ²	3375
4	Даатгалын зуучлагч	24	1 ³		25
5	Даатгалын хохирол үнэлэгч	17	2 ⁴		19
6	Актуарч	15			15
7	Жолоочийн даатгалын зөвшөөрөл	16			16
8	Даатгалын зуучлагч компанийн салбар	77	1 ⁵		78
9	Даатгалын компанийн төлөөлөгчийн газар	7			7
10	Даатгалын хохирол үнэлэгч компанийн салбар	9	3 ⁶		11

¹Хорооны даргын 2014 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 197 дугаар тушаалаар “Тэнгэр даатгал” ХХК-ийн 37 иргэнд даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон байна.

²Хорооны даргын 2014 оны 07 дугаар сарын 04-ны өдрийн 198 дугаар тушаалаар “Монгол даатгал” ХХК-ийн 1 иргэн, Хорооны даргын 2014 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 215 дугаар тушаалаар “Миг даатгал” ХХК-ийн 60 иргэний даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрлийг тус тус хүчингүй болгосон байна.

³Хорооны 2014 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 261 дүгээр тогтоолоор “Ар Эм Ай Би” ХХК-д даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосон байна.

⁴Хорооны 2014 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 260 дугаар тогтоолоор “Ухаашүрт консалтинг” ХХК-д, мөн өдрийн 259 дүгээр тогтоолоор “Лэндс” ХХК-д даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус олгосон байна.

⁵Хорооны даргын 2014 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 216 дугаар тушаалаар “Лоялти солишн” ХХК-д Баянзүрх дүүргийн 8 дугаар хороонд даатгалын зуучлагчийн салбар нээн ажиллуулахыг зөвшөөрсөн байна.

⁶Хорооны даргын 2014 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 210 дугаар тушаалаар “Итгэлт эстимэйт” ХХК-д Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт, мөн өдрийн 209 дүгээр тушаалаар “Ашид билгүүн” ХХК-д Сүхбаатар, Хан-уул дүүрэгт даатгалын хохирол үнэлэгчийн салбар нээн ажиллуулахыг тус тус зөвшөөрсөн байна.

2. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ:

Даатгалын байгууллагуудын 2014 оны 07 дугаар сарын даатгалын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг сарын болон өссөн дүнгээр харуулбал дараах байдалтай байна.

Ердийн даатгалын компаниудын хувьд :

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2014.07.30 /сарын дүн/	2014.07.30 /өссөн дүн/
Даатгалын нийт хураамж	9 516 438 554,79	61 070 032 712,25
Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамж	1 163 315 065,07	12 108 775 251,11
Олгосон нийт нөхөн төлбөр	2 168 951 543,74	17 343 376 742,78
Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр	914 873 577,23	7 068 357 496,05
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо	1 952,00	16 930,00
Давхар даатгалд төлсөн хураамж	3 406 345 588,43	21 276 010 806,60
Байгуулсан даатгалын гэрээний тоо	77 854,00	723 499,00
Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний тоо	31 168,00	262 397,00
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамрагдсан даатгуулагчийн тоо	34 104,00	329 665,00
Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	545 207 511 904,12	5 832 962 927 311,50
Хамгийн их дүнтэй нөхөн төлбөр	102 759 731,40	102 759 731,40

2014 оны 07 дугаар сарын байдлаар /өссөн дүнгээр/ даатгалын хураамжийн орлого 61070.0 сая төгрөг, үүнээс жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамж 12108.8 сая төгрөг, олгосон нөхөн төлбөр 17343.4 сая төгрөг ба үүнээс жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр 7068.4 сая төгрөг болсон байна. Эндээс даатгалын хохирлын харьцаа өссөн дүнгээр 28.3 хувь болсон бөгөөд сарын дүнгээр 22.7 хувь байна.

Өмнөх оны мөн үетэй /сарын дүнгээр/ дээрх үзүүлэлтүүдийг харьцуулахад даатгалын хураамжийн орлого 3108.5 сая төгрөгөөр буюу 1.5 дахин, жолоочийн хариуцлагын даатгал 163.6 сая төгрөгөөр буюу 1.2 дахин, олгосон нөхөн төлбөр 258.9 сая төгрөгөөр буюу 1.1 дахин, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр 284.0 сая төгрөгөөр буюу 1.5 дахин тус тус нэмэгдсэн байна.

Ердийн даатгалын компаниудын 2014 оны 07 дугаар сард байгуулсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр даатгалын үнэлгээ бүхий гэрээ нь “Монгол даатгал” ХХК-ийн даатгалын 545.2 тэрбум төгрөгийн үнэлгээтэй гэрээ юм. Мөн хамгийн өндөр дүнтэй нөхөн төлбөрийг “Монгол даатгал” ХХК 102.8 сая төгрөгийг олгосон байна.

Урт хугацааны даатгалын компанийн хувьд :

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2014/07/30 сарын дүн	2014/07/30 өссөн дүн
Даатгалын нийт хураамж	257 322 098,00	965 028 800,38
Олгосон нийт нөхөн төлбөр	54 808 241,00	290 516 518,00
Давхар даатгалд төлсөн хураамж	11 289 983,00	15 874 052,00
Байгуулсан даатгалын гэрээний тоо	12,00	193,00
Насан туршийн даатгал	2,00	8,00
Эрүүл мэндийн даатгал	3,00	10,00
Сургалтын төлбөрийн хуримтлалын даатгалд	1,00	14,00
Тэтгэврийн даатгалд	2,00	6,00
Орон сууцны даатгалд	0,00	1,00
Хугацаат амьдралын даатгал	4,00	154,00
Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээтэй гэрээ	0,00	10,00
Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	450 000 000,00	3 495 000 000,00
Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	0,00	8 000 000,00

Урт хугацааны даатгагч 2014 оны 07 дугаар сарын байдлаар өссөн дүнгээр 965.0 сая төгрөгийн даатгалын хураамжийн орлоготой байгаа бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс 388.8 сая төгрөгөөр буюу 1.7 дахин, нөхөн төлбөр 199.2 сая төгрөгөөр буюу 3.1 дахин нэмэгдсэн байна. Даатгалын хохирлын харьцаа 30.1 хувьтай байна.

Даатгалын зуучлагч компаниудын хувьд :

Үзүүлэлт	2014.07.30 /сарын дүн/	2014.07.30 /өссөн дүн/
Нийт орлого	164 429 494 734,75	472 148 089 340,24
Даатгалын зуучлагчийн орлого	384 498 888,14	1 726 952 155,44
Үүнээс: Сайн дурын даатгал	262 844 240,85	734 215 942,59
Албан журмын даатгал	121 654 647,29	977 767 037,76
Даатгуулагчаас зуучлагчаар дамжин төлсөн даатгалын хураамж	1 066 331 734,01	4 499 282 276,24
Зуучилсан даатгалын гэрээний тоо	18 268,00	100 985,00
Зуучилсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээ	104 945 412 000,00	104 945 412 000,00

2014 оны 07 дугаар сарын байдлаар даатгалын зуучлагч компаниуд / өссөн дүнгээр/ 1726.9 сая төгрөг, /сарын дүнгээр/ 384.5 сая төгрөгийн даатгалын зуучлалын орлоготой ажилласан байна. Үүний 68.3 хувийг сайн дурын даатгалаас үлдсэн хувийг албан журмын даатгалын хураамжийн орлогоос бүрдүүлсэн байна. “Асимон брокерс” ХХК хамгийн өндөр үнэлгээтэй буюу 104.9 тэрбум төгрөгийн даатгалын гэрээг зуучилсан байна.

Даатгалын зуучлагч компаниудаас “Эм жи ай би” ХХК, “Юу бай би” ХХК, “Монголиан интернэшнл брокерс” ХХК, “Эс ай би эс” ХХК, “Аме” ХХК, “Васнью солюшн” ХХК-иуд тус тус орлогогүй ажилласан байна.

Даатгалын хохирол үнэлэгч компаниудын хувьд :

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2014.07.30 /сарын дүн/	2014.07.30 /өссөн дүн/
Нийт орлого	49 193 780,91	584 332 335,21
Даатгалын хохирол үнэлгээний орлого	42 137 448,00	309 836 266,34
Үүнээс: Сайн дурын даатгал	11 303 873,91	93 332 074,55
Албан журмын даатгал	32 799 674,09	215 103 691,79
Үнэлсэн даатгалын хохирлын тоо	1 894,00	15 212,00
Үнэлсэн даатгалын хохирлоос хамгийн өндөр хохирлын дүн	22 818 000,00	22 818 000,00

2014 оны 07 дугаар сарын байдлаар /өссөн дүнгээр/ даатгалын хохирол үнэлэгч компаниуд 309.8 сая төгрөгийн хохирол үнэлгээний орлоготой ажилласан байна. Үүнээс 30.1 хувийг сайн дурын, үлдсэн хувийг албан журмын даатгалын хохирлын үнэлгээний орлогоос төвлөрүүлсэн байна.

“Ашид билгүүн” ХХК нь даатгалын хохирлоос хамгийн өндөр хохирлын дүн болох 20.5 сая төгрөгийн үнэлгээг хийсэн байна.

Бусад

Хорооны 2014 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 258 дугаар тогтоолоор “Гэр даатгал” ХХК-ийн эрх бүхий албан тушаалтныг томилохыг зөвшөөрсөн байна.

ДААТГАЛЫН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС